

БАТЛАВ,
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА



С.БАТБОЛД

**“ХӨШИГИЙН ХӨНДИЙ ТУННЭЛ” ТӨСЛИЙН УРЬДЧИЛСАН ТЕХНИК, ЭДИЙН
ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ, ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР
УЛААНБААТАР, ТӨВ, ХӨШИГИЙН ХӨНДИЙ/-ЫН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ**

ЗТХЯ/20240103132 дугаартай “Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ боловсруулах зөвлөх үйлчилгээний Тендер шалгаруулалтын баримт бичгийн Тендер шалгаруулалтын зааварчилгааны 11.1-д “Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно” гэж заасны дагуу ажлын даалгаварт дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах:

1. “Хөшигийн хөндий туннел” төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв /Улаанбаатар, Төв, Хөшигийн хөндий/ боловсруулах Ажлын даалгаврын хоёрдугаар бүлэг **“ТӨСЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭ”**-ний “Энэхүү төслийн хүрээнд Улаанбаатар хотын төвөөс Богдхан Уулыг нэвтрэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших Шинэ Зуунмод хоттой холбох техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна” гэснийг “Энэхүү төслийн хүрээнд Туул гол дээгүүр гүүрэн байгууламжаар холбогдон Богдхан Уулыг нэвтрэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших Шинэ Зуунмод хоттой холбох туннел, ган татлага бүхий гүүрэн байгууламжийн (цаашид “гүүрэн байгууламж” гэх) техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулна” гэж өөрчлөх;

2. Ажлын даалгаврын тавдугаар бүлэг **“ТЭЗҮ-ИЙН ТАЙЛАНГИЙН ИЖ БҮРДЭЛ”**-ийн 2.1, 2.6, 2.28-д “... замын байгууламж,” гэсний дараа, 2.23-д “авто зам,” гэсний дараа, 6.12, 6.16-д “туннел” гэсний дараа “гүүрэн байгууламж” гэж тус тус, 2.4-т “... харьцуулалт” гэсний дараа “(авто зам, замын байгууламж, гүүрэн байгууламж, туннел)” гэж, 2.11-д “Авто замын” гэсний дараа “болон гүүрэн байгууламжийн”, 5.4-т “замын байгууламжийн” гэсний дараа “болон гүүрэн байгууламж, туннелийн” гэж тус тус нэмэлт оруулах;

3. Ажлын даалгаврын тавдугаар бүлэг **“ТЭЗҮ-ИЙН ТАЙЛАНГИЙН ИЖ БҮРДЭЛ”**-д:

“6.45. Гүүр баригдах байршлын инженер хайгуулын судалгааг нарийвчлан гаргаж, тайлан боловсруулах ба судалгааны үзүүлэлт, ачааллын тооцоонд үндэслэн гүүрийн хийцлэлийг оновчтой тодорхойлон сонгох”

“6.46. Гүүрийн загвар, хийцийг хүрээлэн буй орчинтой уялдуулж, архитектурын шинэлэг шийдлээр төлөвлөх” гэсэн заалт тус тус нэмэх;

4. Ажлын даалгаврын тавдугаар бүлэг “**ТЭЗҮ-ИЙН ТАЙЛАНГИЙН ИЖ БҮРДЭЛ**”-ийн "6.45-6.54" гэсэн дугаарыг "6.47-6.56" гэж өөрчилсүгэй.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.

---oOo---
